

ОРЧИН ҮЕИЙН НИЙГЭМД УЛС ТӨРИЙН МЕНЕЖМЕНТИЙН
ЭЗЛЭХ БАЙР СУУРЬ, ГҮЙЦЭТГЭХ ҮҮРЭГ

Ц.БАТБОЛД

Доктор, дэд проф, МУИС, ШУС, Нийгмийн Ухааны Салбар.

Улс Төр Сулалын тэнхим

Н.АРИУНАА

Докторант

Түлхүүр үг: Улс төрийн менежмент, улс төрийн удирдлага, оновчтой байх зарчим, удирдлагын объект ба субъект, улс төрийн харилцаа ба улс төрийн менежмент, улс төрийн нэр хүнд ба хүндлэл

Аннотация: Политический менеджмент является одним из важнейших инструментов целенаправленного, сознательного, планомерного регулирования системы общественных отношений, а также поиска новых способов включения людей и их интересов в процесс преобразования жизни. Сегодняшний политический менеджер, должен не только организовывать и координировать деятельность различных государственных, политических или общественных организационных структур для реализации их миссии, но также принимать социально значимые решения и реализовывать их так, чтобы это не разрушало, а помогало жизнедеятельности всего общества или его отдельных сообществ. Управление - это важная и неотъемлемая часть политической жизни общества. С его помощью решаются как масштабные задачи координации политических, экономических и социальных процессов в обществе, так и более мелкие, связанные с достижением конкретных целей и задач, таких как: завоевание доверия масс, победа на выборах, разрешение конфликтных ситуаций и т.д. Управленческие отношения в политике многообразны.

Саяхан болтол улс төрийн шинжлэх ухаанд улс төрийн субъектийн бие даасан парадигмыг үндэс болгон улс төрийн үйл явцыг өөрийгөө тохируулагч үйл явц хэмээн үзэж байв. Хожмоо удирдлагын технологийг төр улсын удирдлагын хэмжээнд хэрэглэх, мөн улс төрийн орон зайд өргөн хүрээтэй чиглэсэн зорилго бүхий зохион байгуулалтын бүтцийг бий болгох замаар улс төрд оролцогчдын үйл байдалд бодлоготой нөлөөлөл үзүүлж үр дүнд хүрэх боломжийн талаарх төсөөллүүд бүрэлдэж тогтсон юм. Ингэснээр "улс төрийн бодлого" ба "удирдлага" хэмээх категориудын харилцан хамаарал, уялдаа холбоог таньж мэдэхэд шинэлэг ойлголт болох "улс төрийн менежмент"-ийн нийгмийн хөгжилд гүйцэтгэх үүрэг, ач холбогчдын талаар өгүүлэх зорилго бид тавьсан юм. Улс төрийн менежмент бол улс төрийн амьдрал дахь удирдлагын харилцааны нэгэн төрөл бөгөөд төр улсын өмнө төдийгүй улс төрийн нам, хөдөлгөөн, улс төрийн лидерүүдийн хувьд тулгамдаж буй тухайлбал, төр улсад удирдлагын оновчтой механизмыг (ЕЕЕ буюу хэмнэлт, бүтээмж, үр ашиг- Н.А) хэрхэн бүрдүүлж төлөвшүүлэх, удирдах албан тушаалтнууд иргэдээс хэрхэн итгэл, нэр хүнд олж, түүнийгээ хүлээн зөвшөөрүүлэх, сонгуульд ялалт байгуулахын тулд сонгогчдын дэмжлэг талархлыг хүлээх, улс төрийн таагүй нөхцөл байдлаас хэрхэн нэр төртэй гарах гарц, өөрийн өрсөлдөгч нартаа нөлөөлөх чадвараа яаж бүрдүүлэхэв гээд олон асуудлыг шийдвэрлэх тааламжтай нөхцлийг бүрдүүлэхэд чиглэсэн удирдлагын өвөрмөц арга барил гэж үзэж болно. Дээр тоочсон улс төрийн зорилтуудыг дан ганц удирдлагын уламжлалт аргуудын тусламжтайгаар шийдвэрлэх боломжгүй. Тиймээс ардчилсан нийгэмд гаргасан шийдвэрийг хүмүүс бүх нийтээрээ ягштал дагаж мөрдөж гүйцэтгэх албадлагын хэм хэмжээ, дүрэм журам, хууль тогтоомж бүтээж гаргаж байсан цаг үе аль хэдийн үеэ өнгөрөөжээ. Жишээ нь: өөрийн улс орны ерөнхийлөгчөө хүндлэж хайрлахыг үүрэг болгосон зарлиг байж болох уу? Ардчиллын нөхцөлд сонгогчдод хүчний дарамт үзүүлэх нь санаанд багтамгүй хэрэг биз дээ. Тэр бүү хэл улс төрийн мөргөлдөөнт нөхцөл байдлыг шийдвэрлэхэд аль болох хүч хэрэглэх явдлаас зайлсхийсэн сөргөлдөгч талдаа нөлөөлөх шинэлэг арга зам, механизмыг урьдал болгодог нь олон улсын улс төрийн практикт аль хэдийнээ ажил хэрэг болж ирлээ.

Ингэхлээр улс төрийн менежментийн хүрээнд удирдлагын субъект тавьсан зорилгоо хангах үүднээс улс төрийн засаглалын тогтсон (статусный- Н.А) нөөц, легитим хүч хэрэглэх эрхийг ашиглах бус харин хүмүүсийн улс төрийн зорилго, сонирхолд нийцсэн үйл байдал, үзэл бодолд гарсан өөрчлөлтийг мэдэрсэн өвөрмөц арга барил, аргуудыг ашиглана гэсэн үг. Удирдлагын харилцааны төрлүүд улс төртэй өөртэй нь хамт улс төрийн практикт нэн эрт үеэс үүсэн тогтнож иржээ. Аль ч

төр улсын засаглагч этгээд ямагт өөрийн нэр хүндийг өсгөхийг хичээж ирсэн ба түүний зөвлөхүүд ч энэ асуудлыг шийдвэрлэхэд нь идэвхтэй тусалдаг байжээ. Төр улсын хэргийг шийдэх асуудал дээр ямагт төвөг бэрхшээлтэй тохиолдлууд үүсдэг бөгөөд алс холын хараатай улс төрчид хүч хэрэглэх, албадлагын замаар бус харин зальхай арга ухаан, олон түмний тархи угаах үйлдлийг илүүд үздэг байжээ. Флоренцийн сэтгэгч Макиавеллийн “Эзэн хаан” бүтээлийг улс төрийн менежментийн практик зөвлөмж гэж хэлж болно. Учир нь энэ бүтээлд өөрийн нэр хүндэдээ (орчин үеийн улс төрийн шинжлэх ухааны хэллэгээр имиждээ бүрдүүлэхдээ) санаа тавьж буй эзэн хаанд өгсөн тодорхой зөвлөгөөг бичсэн байдаг. Макиавелли улс төрийн онолоо боловсруулахдаа “зорилго нь арга хэрэгслээ зөвтгөдөг” хэмээх зарчмыг удирдлага болгон улс төр ба ёс суртахууныг зааглах замаар прагматик байр суурийг баримталж байсан байдаг.

XX зууны дунд үе хүртэл улс төрийн менежментийг улс төрийн удирдлагын практик гэж адилтган үзсээр ирсэн юм. “Өнөө хэр улс төрийн менежмент, улс төрийн удирдлагын ялгааг гүйцэд тогтоож чадаагүй байна. Тиймээс яаж “удирдлагатай ардчиллын” системийг бүрдүүлэх вэ? гэдэг “асуудлаар эрдэмтэн судлаачдын дунд халуун ярилцлага, мэтгэлцээн өрнөж байна.

Улс төрийн удирдлагын системд улс төрийн менежментийн эзлэх байр суурийг зөв ойлгохын тулд эхлээд түүний хамгийн нийтлэг хэв маягуудыг ангилж үзье. Улс төр дэх удирдлагын анхны хэв маяг бол субстанционал (юмс үзэгдлийн эх үндэс- Н.А) чанар бөгөөд хүмүүс өөрсдийн үйлдэлдээ системлэг бүрдэл, социал бүтэц, чиг үүрэг бүхий харилцаа холбоог нөхөн сэргээхэд өдөөж байдаг объектив үйлчлэлтэй социал механизм буюу үйл явцыг хэлж байгаа юм. Субстанционал удирдлагын тусламжтайгаар улс төрийн системийн нэгдмэл чанар батжиж, чанарын өвөрмөц байдал нь хадгалагдахын зэрэгцээ түүний хөгжил үргэлжилж байдаг. Улс төрийн системийн хүрээнд тийм үндсэн үйл явц-механизм бол улс төрийн нийгэмшилт, институцилэл, легитимчлэл юм. Практик амьдрал дээр субстанционал удирдлага хүмүүст тухайн нийгэмд батлагдсан хэм хэмжээ, дүрэм журамд захирагдаж, тэдгээрийг соёлын үнэт зүйлст (тэр тусмаа улс төрийн соёлын -Н.А) хандах хандлага мэтээр төсөөлөгддөг. Жишээ нь: социализмын үед дан ганц МАХН-ын мэдэлд төр, нийгмийн бүх шатны удирдлага төвлөрч байсан тул тус намын их, бүгд хурлаас дэвшүүлсэн зорилгот төлөвлөгөө, шийдвэрүүд нь “хууль” мэт өргөмжлөгдөж түүнийг биелүүлж хэрэгжүүлэх нь бүх нийтийн ариун үүрэг, нэр төрийн хэрэг болж байв. Энэ социализмын он жилүүдэд үндсэндээ удирдлагын захиргаадалтын арга барил голлож байсан юм.

Удирдлагын реляционал (харилцаа-Н.А) хэв маягаас субъект-объектийн харилцаагаар төлөөлүүлэн хэн удирдлагыг хэрэгжүүлж байна, удирдлагын объект хэн бэ? өөрөөр хэлбэл, удирдлагын шийдвэрийг хэн гүйцэлдүүлэх вэ гэдгийг хялбархан зааглаж болно. Удирдлагын энэ хэв маяг хүмүүсийн чиглэсэн зорилготой, ухамсарласан үйл ажиллагаагаар нөхцөлдсөн байдаг учраас шийдвэр гаргах, бие биедээ нөлөөлөх арга хэрэгсэл нь тодорхой байдаг тул улс төрийн үйл явцад оролцогч хүмүүсийн хувийн зан чанараас ихээхэн хамааралтай байдаг. Энэ онцлогоос болоод удирдлагын энэ хэв маяг хүчтэй ба сул талуудтай. Хүчтэй тал нь гэвэл хүн тухайн системд урьд өмнө нь тогтсон харилцаа холбоог нөхөн сэргээх чадвартай, мөн түүнийг өөрчлөх, боловсронгуй болгох, шинийг сэдэх, тэгснээрээ хөгжлийг түргэтгэх боломжтой. Харизмат лидерүүдийн зоримог үйл ажиллагаа чухал байдаг тул түүхэнд нэрээ үлдээсэн суут зүтгэлтнүүд аль ч улс оронд мөнхөрч үлддэг билээ. Англид У.Черчилль, М.Тетчер, Америкт Ф.Рузвельт, Ж.Кеннеди, Энэтхэгт Ж.Неру, М.Ганди, Францад Д.Голль, Ф.Меттеран гэх, мэт. Сул тал нь: удирдлагын алдаатай шийдвэрийг амьдралд хэрэгжүүлэх гэж туйлшран мэрийж зүтгэх нь хүнийг гарцаагүй алдаа гаргахад хүргэдэг. Ленинийг замгамжлагч гэж өөрийгөө өргөмжилж байсан И.Сталин үзэл суртлын туйлшралд автаж, Зөвлөлтийн олон сая гэр бүлд хэлмэгдүүлэлт авчирсан гунигт түүх байдаг.

Улс төр дэх удирдлагын субъект-объектийн харилцааг гурван үндсэн төрөлд ангилан үзэж болно. Үүнд:

Нэгд, удирдлагын субъектийн үүргийг гүйцэтгэж байгаа төрийн албан тушаалтнууд болон төрийн байгууллага, газрууд нэг талаас, нөгөө талаас нийт хүн ам, түүний хэсэг социал бүлгүүдтэй харилцах харилцаа. Энэ төрлийн харилцаан дахь удирдлагыг гол төлөв төрийн удирдлага гэж нэрлэдэг. Учир нь удирдлагын гол субъект нь төр, түүний байгууллага газрууд, тэнд алба хашиж буй албан тушаалтнууд байдаг. Мөн олон төрөл чиглэлийн удирдлагын үйл ажиллагааг эрхэлдэг гүйцэтгэх засаглалын (засгийн газар, яамд, албан байгууллага г.м) байгууллагын удирдлагыг төрийн захиргааны удирдлага гэж онцгойлдог тал бий.

Хоёрт, Удирдлагын үйл ажиллагааг дэг журамтай болгох, ажлын үр ашгийг дээшлүүлэх зорилгоор төрийн болон улс төрийн байгууллагуудын дотоодод тогтсон удирдлагын харилцаа. Энэ харилцааны

авсан байгаа. Үр дүн нь 15 яамтай 19 сайдтай УИХ-д суудалтай бүх намын төлөөллийг оролцуулсан “Шийдлийн” засгийн газрыг байгуулав.

6. Улс төрийн сөрөг талынхандаа нөлөөлөх. Улс төрийн сөргөлдөгч талуудын үйл ажиллагаа нийгэмд хурцдаад ирвэл улс орны эдийн засаг, нийгмийн хөгжил саатаж улс төрийн тогтворгүй байдал даамжирдаг. Иймд мөргөлдөөнийг үүсгэхгүй байх, нэгэнт үүссэн нөхцөлд түүнийг шийдвэрлэх арга замын асуудал хэзээ ямагт чухал байдаг. Энд хүч хэрэглэх бус, харин мөргөлдөөнт нөхцөл байдлыг зохицуулах онцгой технологийг хэрэглэх шаардлага гардаг юм. Түүгээр ч зогсохгүй төрийн шийдвэр гаргадаг эрх баригчдад нөлөөлөл, шахалт үзүүлэх хэлбэр, арга барилууд байнгад боловсронгуй болж байна. Орчин үеийн нийгэм давхраажиж өөрсдийн сонирхол, эрх ашгийг хамгаалсан олон янзын социал бүлгүүд бий болж бүлгийн сонирхлыг хамгаалсан төрийн байгууллага, албан тушаалтнуудад шахалт үзүүлдэг зохион байгуулалтад аль хэдийнээ орсон юм. Энэ бол бодит зүйл үүнийг тооцохгүй өнгөрч болохгүй.


7. Улс төрийн дэмжлэг олох зорилгоор олон түмнийг дайчлах. Улс төрийн субъектүүдэд тодорхой улс төрийн зорилгоо хангах үүднээс олон түмний дэмжлэгийн жагсаал, цуглаан, хурал зөвөлгөөн г.м зохион байгуулах нь цөөнгүй байдаг. Ийм олон түмнийг хамарсан арга хэмжээ зохиоход сөрөг хүчин төдийгүй эрх баригчид (төрийн бодлого, шийдвэрт хүмүүсийн итгэх итгэлийн төвшинг харуулах үзүүлэлт гэж) хүртэл ач холбогдол өгч анхаарлаа хандуулдаг байна. Ардчилсан нийгэмд хүмүүсийг гудамжинд гарч жагсаж цуглахыг албадахгүй ч, ийм төрлийн үйл ажиллагаанд оролцохыг өдөөж, итгүүлж, мэдрүүлж болдог байна. Ингэхлээр олон түмний санаа бодлын байнгын судалгаа шинжилгээ улс төрийн нам, хүчнүүдэд бодлого, хөтөлбөрөө боловсруулахад зайлшгүй чухал.

Дээр дурдсан зорилтууд бол улс төрийн менежментийн хүрээнд хамаарагдаж байгаа гол асуудлууд юм. Сүүлийн жилүүдэд улс төрийн менежментийн чиглэлээр бичигдсэн ном, зохиолыг уншиж байхад улс төрийн менежмент аль ч улс төрийн бүрдэл бүтцэд байх ёстой зүйл бөгөөд дараах дөрвөн хүрээний төвшинд онцгойлж авч үзсэн байх юм. Үүнд:

1. Аль ч улс төрийн байгууллагын бүх шатны бүтцэд менежмент хийгдэх учиртай. Энэ бүтэц нь оновчтой цэгцтэй. Эмх журамтай байх ёстой.

2. Санхүүгийн хүрээнд: Аливаа улс орон санхүүгийн хувьд бусдаас хараат бус бие даасан аж үйлдвэр, хүнд хөнгөн үйлдвэрлэлээ хөгжүүлэх өөрийн орны онцлогт тохируулан бусад дэд бүтцийн салбараа хөгжүүлэх нь зүйтэй юм. Одоо байгуулагдаж байгаа засгийн газар “Аж үйлдвэрийн яам” гэж байгуулж байгаа нь зөв зүйтэй алхам юм.

3. Хүний нөөцийн хүрээнд: Өнөө үед хүний нөөцийн асуудал чухал асуудлын нэг болсон бөгөөд мэргэжлийн бэлтгэгдсэн боловсон хүчнээ бодлоготойгоор бэлтгэх хэрэгцээ шаардлага зайлшгүй бөгөөд бусад орнууд ч ийм махенизмаар бэлтгэж ирсэн байдаг. Тиймээс яамд, тусгай газруудыг салбараа мэддэг мэргэшсэн боловсон хүчнээр бэхжүүлэх бодлогыг сүүлийн үед тавих болсон нь цаг



үеийн гарцаагүй бодит хэрэгцээ мөн.

4. Техник, технологийн хүрээнд: Техник, технологийн эрин зуун гэж байгаа өнөө үед энэ асуудал чухлаар тавигдаж байгаа юм. Хөгжилтэй орны техник, технологийг өөрийн орны онцлогт тохируулан хэрэглэх, ашиглах энэ дагуу боловсон хүчинээ бэлтгэх явдал чухал билээ. Хөгжсөн үндэстэн гэж өөрт хэрэгтэй зүйлээ бүтээж, ашиглаж, хэрэглэж чаддаг үндэстнийг хэлдэг. Ингэхлээр хөгжсөн үндэстэн гэдэг бол хүн нь гачигдах зүйлгүй амьдрах орчин нөхцөл нь бүрдсэн төр улс гэж ойлгож болно.

Дүгнэлт

Улс төрийн менежмент бол улс төр дэх удирдлагын онцгой төрөл бөгөөд дараах үндсэн зорилтуудыг шийдэх боломжийг бүрдүүлнэ. Улс төрийн менежмент бол мэргэшил мөн. Тиймээс улс төрийн менежментийг гардан хэрэгжүүлдэг улс төрийн мэргэшсэн менежерүүд гэж байдаг. Тэд төрийн болон улс төрийн албыг өндөр төвшинд гүйцэлдүүлэхэд том үүрэг гүйцэтгэдэг. Улс төрийн чадварлаг менежментийг хэрэгжүүлсэнээр:

1. Төрийн болон улс төрийн зүтгэлтэн, лидерийн нэр хүндийг өндөржүүлнэ.
2. Төрийн байгууллага, улс төрийн нам, сонирхлын бүлгийн идэвхтэй үйл ажиллагааны имиж, таатай орчин нөхцлийг бүрдүүлнэ.
3. Аль нэгэн улс төрийн хөтөлбөр, төслийг дэмжигчдийн тоо, хүрээг өргөтгөнө.
4. Улс төрийн эвсэл, холбоодыг өргөтгөн байгуулна.
5. Улс төрийн дэмжлэг авах олон түмнийг дайчлан зохион байгуулна.
6. Төрийн шийдвэр гаргахад нөлөө бүхий хүмүүст эерэгээр нөлөөлнө.

Улс төрийн менежмент нь улс төрийн маркетинг, коммуникаци, олон түмний санаа бодлын судалгаа, улс төрийн пиар (PR-олон нийттэй харилцах) зэрэг улс төрийн салбар ухаануудтай нягт холбоотойгоор хөгжиж байна.

Ашигласан материал

- В.Г. Пушкарева. Политический менеджмент. М., 2002
- Пшизова.С.Н. Можно ли управлять демократией. Часть, I. Полис. №6, 2013, часть, II. №1, 2014
- Dennis W. Johnson, ed., The Routledge Handbook on Political Management /Routledge, 2008/ USA
- Douglas Lathrop, "Political Consultants, Interest Groups, and Issue Advocacy Work: A Lasting Relationship," in Johnson, Routledge Handbook on Political Management, USA